



ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Материалыг шүүх руу шилжүүлэх шийдвэр гарсны дараа урьдчилан хоригдож байгаа хүнд олгоно

Та Та Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч шүүгчээр шүүгдэн урьдчилан хоригдож байгаа бөгөөд таны хэргийг таслахаар засан хүмүүжүүлэх шүүх юмуу иргэдийн төлөөлөгчидтэй шүүх уруу шилжүүлж байна. Уг баримт нь таны эдлэх гол эрх ба танд өгөгдөх гол мэдээллүүдийн талаар таньд сануулна.

Та уг баримтыг урьдчилан хоригдож байгаа хугацаанд өөртөө хадгална

Шүүх хурал болох огноо ба үйлдсэн гэмт үйлдэлтэй танилцах

Таныг буруутгаж буй гэмт үйлдлийн зүйлчлэл, түүний огноо ба үйлдсэн газар байршлыг мэдэх эрхтэй. Таны шүүх хурал болох цагийг хэрэв товлогдсон бол танд мэдэгдэнэ.

Өмгөөлөгчийн туслалцаа

Та өөрийн сонгосон өмгөөлөгч буюу улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгчийн туслалцааг авахаар хүсэлт гаргах эрхтэй.

Та өөрийн өмгөөлөгчтэй бичгээр чөлөөтэй харилцаж болох ба тэр таны шүүх хуралд дуудагдаж, бүх шүүх хуралд оролцоно. Тэр таны баримт бичигтэй танилцах эрхтэй.

Үг хэлэхгүй байх эрх

Та өөрийн шүүх хуралдаа мэдүүлэг өгөх, таниас асуусан асуултанд хариулах эсвэл үг хэлэхгүй чимээгүй байх зэргийг сонгож болно.

Хэлмэрчийн туслалцаа

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Суллагдах хүсэлт гаргах эрх

Ямар ч үед та өөрийнхөө суллагдах талаар хүсэлт тавих эрхтэй. Хэрэв та зөрчил гаргасан тохиолдолд уг хүсэлтийг засах хүмүүжүүлэх шүүх авч хэлэлцэх ба хэрэв та эрүүгийн хэргээр шалгагдаж байвал уг хэргийг мөрдөн байцаалтын хэрэг бүрдүүлэлтийг хянадаг эрүүгийн шүүхээр авч хэлэлцэгдэнэ.

Эрх чөлөө хасах хугацаа

Таны урьдчиланхоригдсон өдрөөс тоолон хэрэв таны хэрэг мөрдөн байцаалтын эрүүгийн шүүхээр хэлэлцэгдэх болсон тохиолдолд таны шүүх хурал хоёр сарын дотор явагдах болно, хэрэв иргэдийн төлөөлөгчидтэй шүүх таны хэргийг шийдэх тохиолдолд нэг жилийн дотор шүүх хурал болно.

Зарим хүний талаархи мэдээлэл

Та өөрийн дурын болон ялангуяа өөрийн гэр бүлийн гишүүдэд урьдчилан хоригдож байгаа тухай мэдэгдэх эрхтэй.

Хэрэв та гадаад улсын иргэн бол өөрийн улсын консулын газарт мэдэгдэх эрхтэй.

Эмчийн үзлэг

Та эмчийн үзлэгээр орох хүсэлт гаргаж болно.

Таны хавтаст хэргийг үзэх

Та хавтаст хэргийн хуулбарыг өөртөө авч болох ба боломжгүй тохиолдолд түүний цахим хэлбэрийг авч болно.